

МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА, МЭРГЭЖИЛТНИЙ БЭЛТГЭЛ

Д. Товуудорж, Л. Жамц, УБИС-ийн багш

Улс ардын аж ахуйн салбарт ажиллах төрөл бүрийн мэргэжилтэн мэргэжилтэй ажилчин, малчны залуу халааг бэлтгэхэд сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох ажил чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сурагчдад мэргэжлийн баримжаа олгох ажлын зорилго нь тэдний политехник бэлтгэлийг сайжруулах, хөдөлмөрийн үйл ажиллагааны янз бүрийн хэлбэрүүдтэй танилцуулах мэргэжлээ зөв сонгоход туслах явдал юм. Өөрөөр хэлбэл сурагчдад мэргэжлийн баримжаа олгох ажил нь нийгмийн хэрэгцээ тэдний авьяас чадварт тохируулан ажил мэргэжлээ сонгон авахад нь туслах зорилгоор явуулж байгаа сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны нэгдмэл тогтолцоо бөгөөд ерөнхий боловсролын дунд сургуулийн сургалт-хүмүүжлийн ажлын салшгүй нэг хэсэг юм.

Мэргэжил бүхэн сайхан гэдэг нь эргэлзээгүй боловч мэргэжлээ нийгмийн хэрэгцээ шаардлага, өөрийн чадвар авьяас сонирхолд тохируулан сонгон авч чадсан хүн л түүний сайхныг амтлах учиртай.

Сурагчдаар ирээдүйн мэргэжлийг нь зөв сонгуулахын тулд улс орныхоо орчин үеийн амьдрал, улс ардын аж ахуйн хөгжлийн хэтийн төлөвтэй танилцуулах, үйлдвэрлэлийн гол гол салбарын техник технологийн талаар тодорхой мэдлэг эзэмшүүлэх, тухайн мэргэжлийн хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, ажлын онцлог, гаргаж буй шинэ санаачилга, тэргүүн туршлагаас мэдүүлэх шаардлагатай. Дугуйлан, саналаараа сонгон суралцах хичээлүүд нь орон нутгийн аж ахуйн голлох салбарын зохион байгуулалт, хэтийн төлөв, хэрэгцээ шаардлагатай уялдан нийцэж байх нь чухал. Сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгоход ЕБДС-ийн сургалт-хүмүүжлийн ажлыг бүхэлд нь чиглүүлэх нь чухал юм. Багш бүр сурагчаа бүх талаас нь бидний ярьдгаар арван хуруу шигээ л мэддэг баймааж л энэ ажлын хувь заяа амжилттай шийдвэрлэгдэх болно. Ялангуяа анги удирдсан багш сурагчдынхаа сурлага, сахилга, авьяас сонирхон, биеийн эрүүл мэндийн байдал, хувийн зан төлөв, эцэг эх, ах эгч нарын ажил эрхлэлт зэргийг гоц сайн мэддэг, сурагчид ч өөрийнхөө мэдлэгийн төвшин авьяас сонирхол, биеийн эрүүл мэндийн байдлаа зөв үнэлж байх нь

ирээдүйн мэргэжлээ зөв сонгон авахад тусална. Ингэж бодит байр суурингаас хандаж ажиллах явдал л дутагдаж байна.

Сургууль дээрх мэргэжлийн баримжаа олгож байгаа ажлын агуулга арга барил нь сурагчдын мэдлэгийн төвшин амьдралын туршлага, нас сэтгэхүйн онцлог, хувийн сонирхолд нийцэж л байж чадвал мэргэжлийн чиг баримжаа тогтож мэргэжлээ өөрөө чөлөөтэй сонгох нөхцөл бүрдэнэ.

Хөдөлмөр, мэргэжлийн чиг баримжааг өсвөр үеийнхэнд таниулах ажлыг хөдөлмөрлөхгүйгээр амьдарч болохгүйг зөв ойлгуулж, хөдөлмөрийн хуваарь, мэргэжил, түүний улс ардын аж ахуйн хэрэгцээ шаардлага, ач холбогдол, нийгэмд эзлэх байр суурь, үүрэг хариуцлагыг ухамсарлуулж сурагчдаас өөрийнхөө сонирхол, авьяас мэдлэг, чадвар, боломж, зан төрх зэргийг харгалзаж хувийн болон нийгмийн эрх ашигт зохицуулахыг ойлгуулсны үндсэн дээр явуулна.

Сурагчдыг зохион байгуулалттайгаар хадлан тэжээл бэлтгэх, тариа ногоо тарих хураах, төл бойжуулах, мал тэжээж арчлах, ноос ноолуур, хялгас хөөврийг авах сүү, цагаан идээ боловсруулах, нэг ба олон наст ургамал мод бут сөөг тарьж тордох, үйлдвэр барилгад ажиллах бэлчээрийн олон наст ургамлын үр түүх гэх мэт олон хэлбэрээр оролцуулж байгаа нь аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн баримжаа олгоход зохих нөлөө үзүүлж байна. Залуучууд хөдөлмөрлөсний үр дүнд л үзэл бодол, зан суртахуун, бие бялдар, гоо зүй, хөдөлмөр, оюун ухааны хүмүүжлийн төлөвшил олж чадна.

Багш хүн бүх талын мэдлэгтэй, авьяастай баймааж л сурагчдыг үлгэрлэн дагуулах болно. Жишээлбэл: газарзүйн багш "Говийн их муж"-ийн тухай заахдаа Д. Пүрэвдоржийн "Сэгс цагаан богд" найраглалын хэсгээс уншихад говь нутгаар явж, Сэгс цагаан богдыг үзэж эгэл жирийн тэмээчин бүсгүйтэй уулзсан юм шиг л сэтгэгдэл төрүүлж, энэ үеэс сурагчдыг эх орныхоо уудам говийг тал бүрээс нь судалдаг геологич газар зүйч, хөрс судлаач, ус зүйч, цаг уурч болох сонирхолтой болгох ажлыг системтэй зохион байгуулбал энэ чиглэлээр ажил мэргэжлээ сонгон авах хүсэлтэй болж болох юм.

Ийм учраас заах сэдвийнхээ агуулгад ажил

мэргэжлийнхээ талаар ойлгоц өгөх зүйлийг тусгах, холбогдох жишээ баримтыг орон нутагт элбэг байдаг ажил мэргэжлийн хүмүүсийн бүтээлч санаачилга, тэргүүн туршлагаар баяжуулах, ажил мэргэжлийн холбогдолтой илтгэл, сонсгол бичүүлэх, тухайн мэргэжлийн онцлогийг тусгасан ном зохиол судлуулж, баримт дүгнэлт цуглуулах, ажлыг эрэмбэ дараатай зохиох нь үр дүнд хүргэнэ.

Аль нэг ажил мэргэжлийг сонирхон сонгон авч байгаа сурагчдад тэр талаар юу уншвал зохихыг зөвлөх, сонирхсон чиглэлээр нь бүтээлч даалгавар өгч тухайн мэргэжилтэй улам гүнзгий танилцуулж сонгосон мэргэжил нь сайн сайхныг амтлуулж тохиолдож болох бэрхшээлийг нь ч мэдүүлэх хэрэгтэй.

УБИС-ийн оюутны дунд сүүлийн 3 жилийн явуулсан судалгаанаас үзэхэд 85,6 хувь нь багшийн мэргэжлийн бэрхшээлтэй талыг мэддэггүй (хариулаагүй), зөвхөн 18,4 хувь нь энэ мэргэжлийг эзэмшихээр зорьсон гэж хариулсан байлаа.

Одоогийн байдлаар VIII, X анги төгсөгчид нь өөрийн сонирхож сонгосон мэргэжлээрээ биш, зөвхөн хуваариар очсон мэргэжилд “азаа туршин” орж байгаагаас "дургүйд хүчгүй" гэгчээр яаж ч мэрийж суралцаад сурлага даа амжилт гаргаж чадахгүйд хүрдэг бэрхшээлтэй учирдаг нь нууц биш ээ.

Бидний явуулсан судалгаагаар 1986-1987 оны хичээлийн жилд УБИС-д элсэгчдийн 49,5 хувь нь багшийн мэргэжлийг сонгосон байсан бол 1987-1988 оны хичээлийн жилд 79,5 хувь нь 1988-1989 оны хичээлийн жилд элсэгчдийн 89.2 хувь болж ахижээ. Гэвч багшийн мэргэжлийг сонирхогчдын сурлагын амжилт нь сонирхоогүй элсэгчдээс доогуур байгаа нь харагдсан юм.

Сурлага сайтай дөмөг нь гадаадад, түүний удаах нь МУИС болон АУИС-д шигшигдэж, хоцорсон нь ХААИС, УБИС-д элсдэг гэдэг ойлголт бий. Үнэн байдал ч ийм ээ.

Эндээс дүгнэлт хийж болох юм. Багшийн мэргэжлийг сонирхогчид яагаад цөөрөв? Багш нарынхаа нийгмийн асуудалд анхааралыг шаардсан шаардлага бус уу?

Багш болох сонирхолтой сурагчдыг багш мэргэжлийн өмнөх бэлтгэлийг хангуулсны үндсэн дээр багш бэлтгэдэг дунд дээд сургуулиудад элсүүлдэг ажлын эхлэл бий болсон нь өнөөгийн оюутан, маргаашийн багшийн бүтэц чанарыг сайжруулахад зүй ёсоор нөлөөлөх арга хэмжээ боллоо. Энэ бүлгийн сурагчдаас багшийн мэргэжлийг хэдий үеэс сонгох болсныг судалж үзэхэд тэдний 33,6 хувь нь сургуулийн өмнөх наснаасаа, 28,4 хувь нь бага ангиасаа, 38,0 хувь

нь V-VIII ангиасаа сонгосон гээд өөр ямар ч мэргэжлээр солихгүй гэсэн байхад УБИС-д элсэгчдийн (1986-1987) онд 36 хувь нь VIII ангиасаа, 64 хувь нь IX-X ангиасаа мэргэжлээ сонгожээ. Эндээс үзвэл (багш мэргэжлийн өргөтгөсөн сургалттай бүлгийг эс оролцуулбал) мэргэжил сонголтыг сургуулийн өмнөх наснаас нь чиглүүлж өгөх ажил учир дутагдалтай байгаа нь харагдаж байна. Энэ нь сурагч, эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгчид бидний ажлын дутагдал гэхээс аргагүй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа нь улс нийгмийн хэрэгцээ шаардлага, сурагч залуучуудын сонирхол авьяас, чадвар сэтгэл зүйн физиологийн онцлог болон эрүүл мэндийн байдал, эцэг эх, төрөл төрөгсөд найз нөхдийн халамж нөлөө, хүн ам зүй, үйлдвэрлэл сургууль, албан байгууллагын байршил зэрэг олон хүчин зүйлээс хамаарах нийгмийн асуудал учраас бүх нийтийн хөдөлмөр, аж амьдралын сайн сайхан ирээдүйн эх суурь юм.

Боловсрол. 1991. №3